



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



World Health
Organization
Representative Office
for Mongolia



БАРИМТЫН ЦОМОГ

Улаанбаатар хот
2020 он

СҮРЬЕЭГ УСТГАХ ЦАГ НЬ БОЛЛОО!

СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР
ЖИЛ БҮРИЙН **3** САРЫН **24** ӨДӨР



СҮРЬЕЭ ДЭЛХИЙ ДАХИНД



2018 онд дэлхий дахинд жилдээ **10 САЯ ХҮН** СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛЖ, **1,5 САЯ ХҮН НАС** БАРСАН БАЙНА.¹

1,1 САЯ ХҮҮХЭД СҮРЬЕЭГЭЭР ӨВЧИЛЖ **205,000 ХҮҮХЭД НАС** БАРСАН.²

ӨДӨРТ **30,000 ХҮН** СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАР АВЧ, **4,000 ХҮН НАС** БАРЖ БАЙНА.³

500,000 ОРЧИМ ХҮН **ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГЭЭР** ӨВЧИЛСӨН БАЙНА.⁴

2019 онд СҮРЬЕЭГИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД **10,4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР** ШААРДЛАГАТАЙ БАЙСАН БА **САНХҮҮГИЙН ДУТАГДАЛ 3,3 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР** БОЛСОН.⁵

ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН **56% НЬ АМЖИЛТТАЙ ЭМЧЛЭГДСЭН.**⁶

НАС БАРАЛТЫН **95%** нь бага болон дунд орлоготой **УЛС ОРНУУДАД** бүртгэгдэж байна.⁷

СҮРЬЕЭ МОНГОЛ УЛСАД

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ БАЙДЛААР

ТООЦООЛСОН 14,000 СҮРЬЕЭГИЙН
ТОХИОЛДЛООС 30% НЬ БУЮУ 4089
НЬ БҮРТГЭГДСЭН. ⁸

ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ
СҮРЬЕЭГИЙН 30% БУЮУ 218
ТОХИОЛДЛЫГ ИЛРҮҮЛСЭН. ⁹

СҮРЬЕЭ ӨВЧНИЙ УЛМААС 265 ХҮН
НАС БАРСАН. ¹⁰

ХҮҮХДИЙН СҮРЬЕЭГИЙН 429
ТОХИОЛДОЛ БҮРТГЭГДСЭНИЙ
113 НЬ 0-4 НАСНЫХАН БАЙНА. ¹¹

НИЙТ ТОХИОЛДЛЫН 57% НЬ
НИЙСЛЭЛД БҮРТГЭГДСЭН. ¹²

СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ 62% НЬ
16-44 НАСНЫХАН БАЙНА. ¹³

ХАЛДВАРТАЙ ХЭЛБЭРИЙН
СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ
АМЖИЛТ НЬ АЙМАГТ 92% БАЙГАА
БОЛ НИЙСЛЭЛД 81% БАЙНА. ¹⁴

НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

- ОНОШЛОГООНЫ ЧАДАВХ СУЛ,
ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ ДУТМАГ.
- ОНОШЛОГДСОН БОЛОВЧ
ЭМЧЛЭГДЭЭГҮЙ ТОХИОЛДОЛ
ЦӨӨНГҮЙ БАЙНА.
- ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН
ТАРХАЛТ **НЭМЭГДЭХ ХАНДЛАГАТАЙ**
БАЙНА.
- 0-4 НАСНЫ ХҮҮХДИЙН СҮРЬЕЭГ
ОНОШЛОХ, ИЛРҮҮЛЭХ ЧАДАВХ СУЛ.
- ХҮН АМ ХЭТ ТӨВЛӨРӨХ, ЯДУУРАЛ.
- ХҮН АМЫН ДУНД ХАЛДВАР
ИДЭВХТЭЙ ТАРХСААР БАЙНА.
- АХИМАГ НАСНЫ ХҮН АМЫН ДУНД
ИЛРҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ.
- НИЙСЛЭЛД ӨВЧТНИЙ 8% НЬ
ЭМЧИЛГЭЭГ ТАСАЛЖ, 8% НЬ
ЭМЧИЛГЭЭ ҮР ДҮНГҮЙ БОЛСОН.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

- ИДЭВХТЭЙ ИЛРҮҮЛЭЛТИЙГ
ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- ХҮН АМД ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОХ, МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААГ НЭМЭГДҮҮЛЭХ
- ОНОШИЛГООНД ШИНЭ
ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ
- ОНОШЛОГДСОН ТОХИОЛДОЛ
БҮРИЙГ ЭМЧЛЭХ
- ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭД
ЗАРЦУУЛАХ УЛСЫН ТӨСВИЙН
САНХҮҮЖИЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ.
- АЖИЛГҮЙДЛЫГ БУУРУУЛАХ,
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ
- БАРИЛГА, БАЙШИНГИЙН АГААР
СЭЛГЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ
- ЭМНЭЛГИЙН ХАЛДВАР
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ
БЭХЖҮҮЛЭХ
- АХИМАГ НАСНЫ ХҮН АМЫН ДУНД
ИЛРҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
- ӨВЧТӨНД НИЙГЭМ, СЭТГЭЛЗҮЙН
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
- ШИНЭ АРГА БАРИЛААР
ЭМЧИЛГЭЭГ ХЯНАХ (ВИДЕО
ХЯНАЛТ, УТАС)
- ӨВЧТӨН, ТҮҮНИЙ ГЭР БҮЛД
ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ
ОЛГОХ




СҮРЬЕЭ ГЭЖ ЮУ ВЭ?




Сүрьеэгийн нянгаар (*Mycobacterium tuberculosis complex*) үүсгэгдэж, **АМЬСГАЛЫН ЗАМААР ДАМЖДАГ ХАЛДВАРТ ӨВЧИН** юм. Сүрьеэгийн нян нь хүний биеийн аль ч эрхтэнийг гэмтээж болох ч ихэнх тохиолдол буюу **70% нь уушгийг өвчлүүлдэг.**


ХЭРХЭН ХАЛДВАРЛАХ ВЭ?



Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүн ханиах, найтаах, ярихад нян агаарт цацагдана.



Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй 1 хүн жилд 10-15 хүнд халдвар тараана.



Сүрьеэтэй хүнтэй гар барих болон хэрэглэж буй эд зүйлсээр халдвар дамжихгүй.

ШИНЖ ТЭМДЭГ



14 хоног ба түүнээс дээш хугацаагаар ханиалгах



Цэр болон цустай цэр гарах



Халуурах



Шөнө хөлрөх



Цээжээр өвдөх




Турах, бие сульдах

СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАР АВСАН ХҮМҮҮСИЙН ЗӨВХӨН 10% НЬ ӨВЧИЛДӨГ.


Сүрьеэгээр ХЭН Ч өвчилж болно.

ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ



ЯАГААД ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ҮҮСДЭГ ВЭ?

Сүрьеэгийн эмчилгээг хяналтгүй хийх, сүрьеэгийн эмийг зохисгүй хэрэглэх, эмийн хангамж тасалдах, эмчилгээг дур мэдэн таслах нь олон эмэнд тэсвэртэй сүрьеэг үүсгэнэ.



Олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй нэг өвчтөнийг эмчлэх зардлаар эмэнд мэдрэг сүрьеэтэй 20 өвчтөнг эмчлэх боломжтой.

СҮРЬЕЭГИЙН ӨВЧЛӨЛД НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛС



ЯДУУРАЛ

Дэлхий дахинд оношлогдож буй сүрьеэгийн бүх шинэ тохиолдлын $\frac{1}{4}$ нь хоол тэжээлийн дутагдалтай байдаг.¹⁵



ХДХВ/ДОХ

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг нас баралтад хүргэх гол шалтгаан нь сүрьеэ өвчин бөгөөд эрүүл хүнтэй харьцуулахад сүрьеэгээр өвчлөх эрсдэл 17-23 дахин өндөр байдаг.¹⁷



ТАМХИ

Тамхины хэрэглээ нь сүрьеэгээр өвчлөх эрсдлийг 2-2,5 дахин нэмэгдүүлдэг ба дэлхий нийтийн сүрьеэгийн тохиолдлын 20% нь тамхидалтаас үүдэлтэй.¹⁶



ЧИХРИЙН ШИЖИН

Чихрийн шижинтэй хүмүүсийн сүрьеэгээр өвдөх эрсдэл нь эрүүл хүмүүсийг бодвол 2-3 дахин өндөр байдаг.¹⁸

СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨН, ТҮҮНИЙ ГЭР БҮЛД УЧИРЧ БУЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

УЛААНБААТАР ХОТ, 2019 оны 6-р сарын 21-ны өдөр Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банктай хамтран ядуурлын 2018 оны тооцооны үр дүнг гаргасан байна. Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж, 1.2 пунктээр буурчээ. Хот суурин газарт ядуу хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. Улаанбаатар хотод 2018 оны байдлаар нийт ядуусын 41.8 хувь нь амьдарч байна.¹⁹

Сүрьеэтэй өвчтөн түүний гэр бүлд дараах асуудал тулгарч байна.

- Сүрьеэгийн эмчилгээ удаан хугацаанд /6-18 сар/ үргэлжилдэг
- Эмийн гаж нөлөө илрэх
- Ажлын байраа алдах
- Санхүүгийн дарамтанд орох
- Ялгаварлан гадуурхалтанд өртөх
- Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг дутагдалтай


2018 онд хийсэн Сүрьеэтэй өвчтөн, түүний гэр бүлд учирч буй зардлын судалгаа:



Сүрьеэтэй өвчтний 39% зээл авсан байна.²⁰



Сүрьеэтэй өвчтний 45,5% ажилгүй болсон байна.²¹



Сүрьеэтэй өвчтөн, түүний гэр бүлийн 70% санхүүгийн дарамтад өртөж байна.²²

Санхүүгийн хүндрэлээс шалтгаалан өвчтнүүд эмчилгээгээ таслах, улмаар бусад хүнд халдвараа тараах эрсдэл нэмэгдэх аюултай байна.

СҮРЬЕЭГИЙН ТАРХАЛТ, НАС БАРАЛТЫГ УДААН ХУГАЦААНЫ УЙГАГҮЙ, ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД БУУРУУЛАХ БӨГӨӨД ДАН ГАНЦ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮЧЭЭР АМЖИЛТАНД ХҮРЭХ БОЛОМЖГҮЙ ЮМ.





СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ СЭРГИЙЛЭХ ҮЙЛСЭД ХАНДИВЛАСАН **1 АМ.ДОЛЛАР** НЬ ЭРГЭЭД **43 АМ.ДОЛЛАРТАЙ** ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ НИЙГЭМД ӨГДӨГ.²³

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

¹⁻⁷ ДЭМБ, Сүрьеэгийн дэлхийн тайлан, 2019
<http://www.who.int/global TB report-2019>

⁸⁻¹⁴ ХӨСҮТ, СТСА Сүрьеэгийн тандалтын тайлан мэдээний эмхэтгэл 2019 он

¹⁵ ДЭМБ, Сүрьеэ ба хоол тэжээлийн тоо баримт
<http://www.who.int/tb/TBnutrition.pdf>

¹⁶ ДЭМБ, Сүрьеэ ба тамхины талаархи тоо баримт
<http://www.who.int/tb/challenges/tobacco/en/>
http://www.who.int/tobacco/publications/health_effects/factsheet_tub_tob.pdf

¹⁷ ДЭМБ, Сүрьеэ ба ХДХВ-ийн талаархи тоо баримт
http://www.who.int/tb/challenges/hiv/tbhiv_factsheet_2014.pdf

¹⁸ ДЭМБ, Сүрьеэ ба чихрийн шижингийн тоо баримт:
www.who.int/tb&diabetes

¹⁹ Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банктай хамтран ядуурлын 2018 оны тооцооны үр дүн

²⁰⁻²² ДЭМБ, Сүрьеэтэй өвчтөн, түүний гэр бүлд учирч буй зардлын судалгаа, Монгол Улс 2018

²³ ДЭМБ, Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр, харилцаа холбоо нөлөөллийн багц
<https://www.who.int/campaigns/world-tb-day/world-tb-day-2020>